

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Хөвсгөл аймгийн Хөдөөгийн шийдэл” ОНӨҮГ-ын 2024 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан.

Аудитын код: ХӨА-2025/002/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089116 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: davaanyam@audit.gov.mn

Гурван Хөх Морьт Аудит ХХК

Гүйцэтгэх захирал: Н.Отгончимэг

Утас: 99051815 Цахим хаяг: gurvankhukhmoritllc@gmail.com

Аудитор: Ш.Саранчимэг

Утас: 99834361 Цахим хаяг: gurvankhukhmoritllc@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	5-8
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	9
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	9-10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт	10-15
4. Аудитын тайлан	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	1-18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. Аудитын илрүүлэлт	18-20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЗБАХ	Техник Зохион Байгуулалтын Арга Хэмжээ
ТӨХК	Төрийн Өмчит Хувьцаат Компани



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 1/296
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХӨДӨӨГИЙН ШИЙДЭЛ ОНӨҮГ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.АМАРБАЯСАХ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн "Хөдөөгийн шийдэл" ОНӨҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Аудитаар дараах зөрчилтэй зүйл илэрлээ. **Үүнд:**

1. Шинэ хөдөө төслийн хүрээнд хэрэгжүүлж 2022 оноос хойш түрээсийн гэрээгээр ашиглуулж байгаа 422 толгой 782,057.7 мянган төгрөгийн дансны үнэтэй бод малд түрээсийн гэрээнд заасны дагуу ашиг шимээс үүссэн 209 ширхэг бод малын үр төлийг санхүүгийн тайланд бүртгээгүй, тооллого тооцоо хийгээгүй, эргэн төлөлтийг хуваарийн дагуу өмчлөгч талд шилжүүлж аваагүй, түрээсээр ашиглуулах гэрээний заалтуудыг бүхэлд нь хэрэгжүүлж ажиллаагүй, үр дүн хангалтгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэснийг зөрчсөн ба "Нийцсэн бөгөөд зохистой", "Оршин байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 69,696.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бизнес төлөвлөгөөний орлогын гүйцэтгэл, авлага, үндсэн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлд онцгой өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Гүйцэтгэх захирал нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Төгрөгөөр	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	76,750,820.20	35,831,326.94
1.1.2	Дансны авлага	63,471,570.00	46,199,610.00
1.1.6	Бараа материал	18,104,480.00	13,550,802.00
1.1.9	Борлуулахаар эзэмшиж буй эргэлтийн хөрөнгө	19,475,00.00	195,159,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	177,801,870.20	290,740,738.94
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,979,936,533.33	2,937,114,033.33
1.2.2	Биет бус хөрөнгө	821,000.00	381,000.00
1.2.3	Биологийн хөрөнгө	782,057,700.00	782,057,700.00
1.2.9	Бусад биет бус хөрөнгө	31,047,000.00	31,047,600.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,793,862,233.33	3,750,599,733.33
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,971,644,103.53	4,041,340,472.27
2.1.1.3	Татварын өр	10,889,575.19	9,658,749.86
2.1.1.4	НДШ-ийн өглөг	578,200.01	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	11,467,775.20	9,658,749.86
2.2	Өр төлбөрийн нийт дүн	11,467,775.20	9,658,749.86
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	3,171,682,200.00	3,347,366,200.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	358,959,128.33	254,760,522.41
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,960,196,328.33	4,031,681,722.41
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	3,960,196,328.33	4,031,681,722.41

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Төгрөгөөр	
		Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (Түрээсийн орлого)	378,305,557.95	210,060,833.52
2	Борлуулалтын өртөг	40,964,000.00	0.00
3	Нийт ашиг (алдагдал)	337,341,557.95	210,060,833.52
	Нийт зардал	260,576,884.12	314,259,439.44
10	Ерөнхий ба удирдлагын зардал	260,576,884.12	313,809,439.44
11	Бусад зардал	0.00	450,000.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	76,764,673.83	(104.198.605.92)
19	Орлогын татварын зардал	7,676,467.38	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	69,088,206.45	(104.198.605.92)
24	Орлогын дүн	69,088,206.45	(104.198.605.92)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Төгрөгөөр			
		Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	429,555,000.00	0.00	3,347,366,200.00	358,959,128.33	4,135,880,328.33
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	429,555,000.00	0.00	3,347,366,200.00	358,959,128.33	4,135,880,328.33

Хөвсгөл аймгийн "Хөдөөгийн шийдэл" ОНӨҮГ-ын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(104,198,605.92)	(104,198,605.92)
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	429,555,000.00	0.00	3,347,366,200.00	254,760,522.41)	4,031,681,722.41

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	297,135,757.95	228,032,793.52
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	289,829,800.00	180,551,140.00
1.1.4	Татаас санхүүжилтийн орлого		30,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	7,305,957.95	17,481,653.52
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	253,320,198.65	268,952,286.78
1.2.1	Ажиллагчдад төлсөн	95,349,260.00	125,690,594.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	24,283,076.58	36,343,259.96
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	85,229,595.29	40,301,591.44
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	15,983,179.57	30,206,198.71
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	26,007,365.00	24,345,891.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	6,064,652.70	11,903,158.12
	Даатгалын төлбөрт төлсөн	327,375.00	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	75,694.51	161,593.55
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	43,815,559.30	(40,919,493.26)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	33,086,260.90	76,750,820.20
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	76,750,820.20	35,831,326.94

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Өмнөх оны үзүүлэлт	2024 он			
			Зорилтот түвшин	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Биелэлт
Нийт орлого	мян.төг	378,304.6	564,806.2	210,060.8	(168,243.8)	(354,745.4)
Нийт хөрөнгийн эргэн төлөлт	мян.төг	281,622.0	417,306.2	119,682.0	(161,940.0)	(297,624.2)
Хөрөнгийн эргэн төлөлтийн орлого	мян.төг	281,622.0	383,830.2	89,402.0	(192,220.0)	(294,428.2)
2023 оны авлагаас	мян.төг	-	33,476.0	30,280.0	30,280.0	(3,196.0)
Хүнсний ногооны үрийн орлого	мян.төг	49,156.8	-	-	(49,156.8)	-
Нийт үйл ажиллагааны орлого	мян.төг	47,525.8	147,500.0	90,378.8	42,853.0	(57,121.2)
Хүнсний ногооны тракторын үйлчилгээний орлого	мян.төг	18,631.8	25,500.0	22,300.0	3,668.2	(3,200.0)
Ногоон тэжээлийн орлого	мян.төг	8,100.0	-	-	(8,100.0)	-
Хадлангийн тракторын түрээсийн орлого	мян.төг	13,489.0	22,000.0	20,597.2	7,108.2	(1,402.8)
Бусад орлого	мян.төг	7,305.0	30,000.0	47,481.7	40,176.7	17,481.7
Үхрийн аж ахуйн орлого	мян.төг	-	70,000.0	-	-	(70,000.0)

**Хөвсгөл аймгийн "Хөдөөгийн шийдэл" ОНӨҮГ-ын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

Нийт үйл ажиллагааны зардал	мян.төг	301,540.9	470,879.3	314,259.4	12,718.6	(156,619.9)
Нийт цалингийн сан	мян.төг	77,615.6	187,569.6	129,348.9	51,733.3	(58,220.7)
ТУЗ-ийн цалингийн зардал	мян.төг	24,750.0	29,520.0	16,820.0	(7,930.0)	(12,700.0)
ТУЗ бичиг хэргийн зардал	мян.төг	2,100.0	2,400.0	-	(2,100.0)	(2,400.0)
НД-ын шимтгэл	мян.төг	18,239.8	51,983.4	21,051.9	2,812.1	(30,931.5)
Хүнсний ногооны тракторын шатахууны зардал	мян.төг	6,200.0	7,200.0	6,000.0	(200.0)	(1,200.0)
Ногоон тэжээл тариалах шатахууны зардал	мян.төг	3,400.0	-	-	(3,400.0)	-
Хадлангийн тракторын шатахууны зардал	мян.төг	8,993.5	9,600.0	7,584.0	(1,409.5)	(2,016.0)
Бичиг хэрэг,оффисын зардал	мян.төг	4,309.1	6,000.0	4,245.0	(64.1)	(1,755.0)
Интернэт, утасны зардал	мян.төг	2,324.0	2,400.0	892.3	(1,431.7)	(1,507.7)
Оффисын түрээс	мян.төг	4,500.0	4,800.0	-	(4,500.0)	(4,800.0)
Дулааны зардал	мян.төг	2,032.0	24,000.0	30,000.0	27,968.0	6,000.0
Цахилгаан дулааны зардал	мян.төг	15,983.2	6,000.0	9,903.3	(6,079.8)	3,903.3
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	мян.төг	1,599.5	3,600.0	2,585.8	986.3	(1,014.3)
Шатахууны зардал	мян.төг	11,613.9	12,000.0	10,810.0	(803.9)	(1,190.0)
Томилолтын зардал	мян.төг	6,005.4	18,000.0	3,209.8	(2,795.6)	(14,790.2)
Бохир усны зардал	мян.төг	-	2,400.0	-	-	(2,400.0)
Техникийн засвар үйлчилгээний зардал	мян.төг	-	-	-	-	-
Хог хаягдлын зардал	мян.төг	-	2,240.0	240.0	240.0	(2,000.0)
Засвар үйлчилгээний зардал	мян.төг	4,800.0	4,000.0	9,072.9	4,272.9	5,072.9
Аудитын Төлбөр	мян.төг	3,000.0	4,000.0	3,000.0	-	(1,000.0)
Газрын төлбөр	мян.төг	496.8	1,000.0	496.8	-	(503.2)
Тээврийн хэрэгслийн оношилгоо	мян.төг	99.0	121.0	-	(99.0)	(121.0)
Тээврийн хэрэгслийн татвар	мян.төг	105.0	105.0	-	(105.0)	(105.0)
Даатгалын үйлчилгээ	мян.төг	327.4	420.0	-	(327.4)	(420.0)
НББ-ийн бодлогын баримт бичиг	мян.төг	3,000.0	-	-	(3,000.0)	-
Халамж, Шагнал урамшууллын зардал	мян.төг	-	2,000.0	450.0	450.0	(1,550.0)
Хөдөлмөр хамгааллын зардал	мян.төг	2,324.8	2,400.0	2,346.6	21.8	(53.4)
Сургалтын зардал	мян.төг	2,800.0	3,000.0	1,135.6	(1,664.4)	(1,864.4)
Зар сурталчилгааны зардал	мян.төг	1,800.4	3,600.0	1,704.0	(96.4)	(1,896.0)
Агуулахын түрээс	мян.төг	6,000.0	8,400.0	6,800.0	800.0	(1,600.0)
Бусад үйл ажиллагааны зардал	мян.төг	-	-	-	-	-
Тээврийн зардал	мян.төг	3,000.0	3,500.0	3,300.0	300.0	(200.0)
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	мян.төг	40,964.0	-	-	(40,964.0)	-
Элэгдлийн зардал	мян.төг	43,262.5	68,620.3	43,262.5	-	(25,357.8)
Татварын өмнөх ашиг/ алдагдал	мян.төг	76,763.7	93,926.9	(104,198.6)	(180,962.3)	(198,125.5)
Татварын зардал	мян.төг	7,676.4	9,392.7	-	(7,676.4)	(9,392.7)
Татварын дараах ашиг	мян.төг	69,087.3	84,534.2	(104,198.6)	(173,286.0)	(188,732.8)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Аудитын код: ХӨА-2025/002/НА-СТА-ОНӨҮГ

3.3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Хөдөөгийн шийдэл ОНӨҮГ-ыг Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны 10 дугаар тогтоолоор үүсгэн байгуулж, компанийн дүрмийг баталсан байна.

Хөдөөгийн шийдэл ОНӨҮГ-ын компанийн зорилго, зорилтыг компанийн дүрэмд хөдөө аж ахуйн салбарын бизнесийн үйл ажиллагаагаар дамжуулан байгалийн эрс тэс нөхцөлд зохицсон, орчин үеийн дэвшилтэт техник, хэрэгслийг нэвтрүүлэх, шинжлэх ухааны ололттой технологийг нутагшуулах, нэгжээс авах үр ашгийг нэмэгдүүлж, эрүүл хүнс, чанартай бараа бүтээгдэхүүнийг орон нутагтаа үйлдвэрлэх зорилготой иргэд, аж ахуйн нэгжийг чадавхжуулахад шаардагдах эх үүсвэрийг улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүү, хөрөнгийн хамгийн бага эх үүсвэрээр санхүүжүүлж дэмжлэг үзүүлэхэд оршино" гэж тодорхойлсон байна.

Хөдөөгийн шийдэл ОНӨҮГ-ын даргын тушаалаар улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн техник, тоног төхөөрөмж, шилмэл үүлдрийн мал, зөгий, хүнсний ногооны үр гэх мэт хөрөнгийг хөдөө аж ахуй, газар тариалан эрхэлж байгаа иргэд, аж ахуйн нэгжид түрээсийн болон эргэн төлөгдөх нөхцөлөөр гэрээний тусгайлсан нөхцөлөөр борлуулах, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг явуулж байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Компанийн дүрэмд заасны дагуу тус компани нь Иргэний хууль, Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай, Компанийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийн дагуу "Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани" хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Компанийн дүрэмд зааснаар ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах зарыг 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр "Хөвсгөлийн өнгө" цахим хуудсаар олон нийтэд мэдээлж 2 гишүүнийг улируулан, 7 гишүүнийг шинээр сонгож 9 хүний бүрэлдэхүүнтэй ТУЗ ажиллаж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь зарим ажил гүйлгээг аккрузл сууриар хөтлөөгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу үнэн зөв толилуулаагүй байна гэж үзлээ.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Хөдөөгийн шийдэл ОНӨҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:

Хөдөөгийн шийдэл ОНӨҮГ-ын гүйцэтгэх захирлын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг ашиглаж байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн гол бодлогод өөрчлөлт ороогүй байна.

**Хөвсгөл аймгийн "Хөдөөгийн шийдэл" ОНӨҮГ-ын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 69,676.4 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн байна.

Хүснэгт №-1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	177,801.9	290,740.7	112,938.9
МӨНГӨН ХӨРӨНГӨ	76,750.8	35,831.3	(40,919.5)
АВЛАГА	63,471.6	46,199.6	(17,272.0)
БАРАА МАТЕРИАЛ	37,579.5	208,709.8	171,130.3
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,793,862.2	3,750,599.7	(43,262.5)
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,793,862.2	3,750,599.7	(43,262.5)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,971,664.1	4,041,340.5	69,676.4
НИЙТ ӨР ТӨЛБӨР	11,467.8	9,658.7	(1,809.0)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,960,196.3	4,031,681.7	71,485.4
Засгийн газрын хувь оролцоо	3,960,196.3	4,031,681.7	71,485.4
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,971,664.1	4,041,340.5	69,676.4

Тайлант оны мөнгөн хөрөнгө 40,919.5 мянган төгрөгөөр, авлага 17,272.0 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгө 43,262.5 мянган төгрөгөөр тус тус буурч, бараа материал 171,130.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд банкин дахь мөнгөн хөрөнгө 35,831.3 мянган төгрөг байна.

Бараа материалын дансанд 36,565.0 мянган төгрөгийн материалыг худалдан авч, 41,118.7 мянган төгрөгийн материалыг зарцуулж мөн, ИТХ-ын даргын 2024 оны 05 дугаар сарын 28-ны А/47 тогтоолоор Хөвсгөл аймгийн ЗДТГ-аас 175,684.0 мянган төгрөгийн борлуулах зориулалттай хөрөнгө шилжиж ирсэн байна.

Тайлант онд АНОАТ-ын өр 7676,2 мянган төгрөг, ХАОАТ-ын өр 1982,5 мянган төгрөг нийт 9,658.7 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Илрүүлэлт: Борлуулах зорилготой иргэдэд олгосон хөрөнгийн эргэн төлөлтөөс үүссэн 46,199.6 мянган төгрөгийн авлагаас гэрээний хугацаа хэтэрсэн 40,354.6 мянган төгрөг, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 27,060.6 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 20 дугаар зүйл. Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг 20.1.7-д Тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ 20.2.6-д Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Зөвлөмж өгөх

Илрүүлэлт: Барилга байгууламж дансанд бүртгэлтэй 14,528.0 мянган төгрөгийн дансны үнэтэй хашаанд элэгдэл тооцоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.үнэн зөв байх гэсэн заалттай нийцээгүй бөгөөд "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөвлөмж өгөх.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хөдөөгийн шийдэл ОНӨҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Аудитын код: ХӨА-2025/002/НА-СТА-ОНӨҮГ

Хөдөөгийн шийдэл ОНӨҮГ-ын ТУЗ-ийн 2024 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 04 дугаар тогтоолоор 2024 оны бизнес төлөвлөгөөний орлогыг 564,806.2 мянган төгрөгөөр, нийт зардлыг 470,879.3 мянган төгрөгөөр, тайлант үеийн ашгийг 84,534.1 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

Гүйцэтгэлээр 210,060.8 мянган төгрөгийн орлого, 314,259.4 мянган төгрөгийн зардалтай 104,198.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Тайлант онд зорилтот түвшний орлогын гүйцэтгэл 210,060.8 мянган төгрөг тайлагнаж төлөвлөснөөс 354,745.4 мянган төгрөгөөр тасарч 104,198.6 мянган төгрөгийн алдагдалтай, борлуулалтын орлогын нэг төгрөг тутамд ногдох зардал 1.5 төгрөг байна.

Нийт орлогын төлөвлөгөө 62.8 хувиар тасарсан байгаа нь Шинэ хөдөө төслийн хүрээнд хэрэгжүүлсэн түрээсээр ашиглуулсан хөрөнгийн эргэн төлөлтийн орлогыг 297,624.2 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн, үхрийн аж ахуйн орлого 70,000.0 мянган төгрөг биелээгүй зэргээс голлон шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 314,259.4 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 156,619.9 мянган төгрөгийг дутуу зарцуулсан нь зорилтод түвшинд төлөвлөсөн зарим үйл ажиллагаа хийгдээгүйгээс орон тооны дутуу цалин, шимтгэлийн зардал болон холбогдох зарцуулалт гараагүйгээс шалтгаалсан байна.

Илрүүлэлт: Тайлант онд зорилтот түвшний орлогын гүйцэтгэл 210,060.8 мянган төгрөг тайлагнаж төлөвлөснөөс 354,745.4 мянган төгрөгөөр тасарч 104,198.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн Захирал дараахь эрх, үүрэгтэй 20.3 дугаар зүйлийн Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

Илрүүлэлт: Шинэ хөдөө төслийн хүрээнд хэрэгжүүлж 2022 оноос хойш түрээсийн гэрээгээр ашиглуулж байгаа 422 толгой 782,057.7 мянган төгрөгийн дансны үнэтэй бод малд түрээсийн гэрээнд заасны дагуу ашиг шимээс үүссэн 209 ширхэг бод малын үр төлийг санхүүгийн тайланд бүртгээгүй, тооллого тооцоо хийгээгүй, эргэн төлөлтийг хуваарийн дагуу өмчлөгч талд шилжүүлж аваагүй, түрээсээр ашиглуулах гэрээний заалтуудыг бүхэлд нь хэрэгжүүлж ажиллаагүй, үр дүн хангалтгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэснийг зөрчсөн ба "Нийцсэн бөгөөд зохистой", "Оршин байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн "Хөдөөгийн шийдэл" ОНӨҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани ТӨҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн

Аудитын код: ХӨА-2025/002/НА-СТА-ОНӨҮГ

буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг "Гурван хөх морьт аудит" ХХК-ийн туслах аудитор Б.Баттуяа, аудитор Ш.Саранчимэг, нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг гүйцэтгэх захирал Н.Отгончимэг хэрэгжүүлж, төрийн аудитын байгууллагаас хоёр дахь шатны хяналтыг ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн "Хөдөөгийн шийдэл" ОНӨҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Гурван хөх морьт аудит ХХК-д 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 4/09 дугаартай албан бичгээр 2024 оны 02 дугаар сарын 10-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн тайланг, суурь үзүүлэлтээр 260,576.9 мянган төгрөгийн нийт зардлыг сонгосон.

Материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоон сонгосон суурь үзүүлэлтээс тооцож, байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлыг 3,908.7 мянган төгрөгөөр тогтоож баримтжууллаа.

Ажлын баримтад материаллаг байдлын суурь үзүүлэлт, хувь хэмжээг сонгосон шалтгаан тайлбар болон материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзэх шалтгаан, тайлбарыг тусгасан болно.

Санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,981.5 төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтын сорилыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4,000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хөдөөгийн шийдэл ОНӨҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянаж үзэхэд зөрчилтэй асуудлууд илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилтэй асуудал илрээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 33,476.5 мянган төгрөгийн авлага барагдуулахтай холбоотой зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт 5. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	33,476.5	4	30,280.0	87.5%
Нийт дүн	4	33,476.5	4	30,280.0	87.5%

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4 зөвлөмжийн биелэлт 87.5 хувьтай хэрэгжсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Төслийн үр дүн ашиг шимээс жил бүр үүсэх төл малын дэлгэрэнгүй судалгаа хийгээгүй, төл мал нэмэгдээгүй шалтгааныг тодруулж баримтжуулсан ажлын тайлангүй, төрийн өмчийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжсэн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах замаар аймгийн ХАА-н бизнесийг хөгжүүлэх, дэмжих зорилготой үйл ажиллагааны үр дүн хангалтгүй байна. Мөн түрээсийн гэрээний салшгүй хэсэг болох барьцааны гэрээ хийгээгүй зэргийг үргэлжлүүлэн авч үзэх асуудал.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 926,610.9 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 782,057.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 144,553.2 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Аудитаар 926,610.9 мянган төгрөгийн материаллаг зөрчил илэрсэн бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг түвшнээс хэтэрсэн тул өөрчлөлттэй санал дүгнэлт өгсөн болно.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй

5.2 Албан шаардлага

Шинэ хөдөө төслийн хүрээнд хэрэгжүүлж 2022 оноос хойш түрээсийн гэрээгээр ашиглуулж байгаа 422 толгой 782,057.7 мянган төгрөгийн дансны үнэтэй бод малд түрээсийн гэрээнд заасны дагуу ашиг шимээс үүссэн 209 ширхэг бод малын үр төлийг санхүүгийн тайланд бүртгээгүй, тооллого тооцоо хийгээгүй, эргэн төлөлтийг хуваарийн дагуу өмчлөгч талд шилжүүлж аваагүй, түрээсээр ашиглуулах гэрээний заалтуудыг бүхэлд нь хэрэгжүүлж ажиллаагүй, үр дүн хангалтгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэснийг зөрчсөн ба "Нийцсэн бөгөөд зохистой", "Оршин

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт Борлуулах зорилготой иргэдэд олгосон хөрөнгийн эргэн төлөлтөөс үүссэн 46,199.6 мянган төгрөгийн авлагаас гэрээний хугацаа хэтэрсэн 40,354.6 мянган төгрөг, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 27,060.6 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 20 дугаар зүйл. Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг 20.1.7-д Тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20. Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ 20.2.6-д Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүйд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

2. Зорилтот түвшний биелэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд зорилтот түвшний орлогын гүйцэтгэл 210,060.8 мянган төгрөг тайлагнаж төлөвлөснөөс 354,745.4 мянган төгрөгөөр тасарч 104,198.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн Захирал дараахь эрх, үүрэгтэй 20.3 дугаар зүйлийн Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан зорилтот түвшний биелэлтийг хэрэгжүүлэн алдагдалгүй ажиллах зөрчлийг давтан гаргахгүй байх

3. Үндсэн хөрөнгийн элэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Барилга байгууламж дансанд бүртгэлтэй 14,528.0 мянган төгрөгийн дансны үнэтэй хашаанд элэгдэл тооцоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. үнэн зөв байх гэсэн заалттай нийцээгүй бөгөөд "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Барилга байгууламж дансанд бүртгэлтэй 14,528.0 мянган төгрөгийн дансны үнэтэй хашаанд элэгдэл тооцож үр дүнг санхүүгийн тайланд тусгах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Хүснэгт №-6. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

								/мянган төгрөгөөр/	
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	40,354.6					1	40,354.6	

Хөвсгөл аймгийн "Хөдөөгийн шийдэл" ОНӨҮГ-ын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Нягтлан бодох бүртгэл тайланд тусгаагүй зөрчил	1	782,057.7			1	782,057.7		
Төлөвлөсөн хэмжээнд үйл ажиллагаа явуулж ашигтай ажиллаагүй байна.	1	104,198.6					1	104,198.6
Үндсэн хөрөнгийн элэгдлийг үнэн зөв тооцоогүй байна.	1	0					1	
Дүн	4	926,610.9			1	782,057.7	3	144,553.2



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

№ 58/А2270440/

Мөрөн сум

ХАА-2025/002/НА-СТА-ОНАТ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Хөдөөгийн шийдэл ОНӨҮГ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шинэ хөдөө төслийн хүрээнд хэрэгжүүлж 2022 оноос хойш түрээсийн гэрээгээр ашиглуулж байгаа 422 толгой 782,057,700 (Долоон зуун наян хоёр сая тавин долоон мянга долоон зуу) төгрөгийн дансны үнэтэй бод малд түрээсийн гэрээнд заасны дагуу ашиг шимээс үүссэн 209 ширхэг бод малын үр төлийг санхүүгийн тайланд бүртгээгүй, тооллого тооцоо хийгээгүй, эргэн төлөлтийг хуваарийн дагуу өмчлөгч талд шилжүүлж аваагүй, түрээсээр ашиглуулах гэрээний заалтуудыг бүхэлд нь хэрэгжүүлж ажиллаагүй, үр дүн хангалтгүй байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно" гэснийг зөрчсөн ба "Нийцсэн бөгөөд зохистой", "Оршин байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10 дахь "аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчлийг таслан зогсоож, түрээсээр ашиглуулах гэрээг мөрдөж ажиллах.

2. Албан шаардлагын биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Хөдөөгийн шийдэл ОНӨҮГ-ын гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Амарбаясах, Нягтлан бодогч Н.Нямжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР

Л.МАНДАХНАРАН

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043

87240-9578